

# “ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн

санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2026/183/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Л.Мандахнаран  
Утас: 99389927 Цахим хаяг:  
[mandakhnaranl@audit.gov.mn](mailto:mandakhnaranl@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Ахлах аудитор: Г.Заяа  
Утас: 95648028, 98828028  
Цахим хаяг: [zaya96884510@gmail.com](mailto:zaya96884510@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

᠒᠐᠒5.᠐᠒.᠒5 № 01/᠒51  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААННУУР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ч.ОЮУНБАДАМ  
ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар нягтлан бодох бүртгэл, төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Байгууллагын даргын тушаалаар баталсан тооллогын комисс нь 328,133.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооллогын дүгнэлт үйлдээгүй, нярав нь 999.1 мянган төгрөгийн бараа материал дутагдуулсан, албан хаагчдад тушаал шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл 673.9 мянган төгрөгийг олгосон зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.4-т *“Тооллогын комисс дараах үүрэгтэй: комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т *“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрээдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ;”*, 13 дугаар зүйлийн 13.4-т *“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны*

хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэснийг зөрчсөн, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс олгох санхүүжилтийг 23,345.4 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бараа материалын бүртгэл тайлантай холбоотой 13,300.4 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэр гаргасан.

#### **Бусад асуудлын хэсэг**

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 28 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 88 хувьтай тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>649,036,172.49</u></b>	<b><u>545,503,681.59</u></b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	402,674,647.85	303,854,926.78
Банкинд байгаа бэлэн мөнгө	402,674,647.85	303,854,926.78
Төгрөг	402,674,647.85	303,854,926.78
Төрийн сангийн харилцах	402,674,647.85	303,854,926.78
<b>АВЛАГА</b>	5,145,798.84	2,725,898.84
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,046,898.84	1,546,898.84
Төлбөртэй үйлчилгээний авлага	4,098,900.00	1,179,000.00
<b>УРЬДЧИЛГАА</b>	21,336,645.69	3,749,915.36
Төсөвт байгууллага	21,336,645.69	3,749,915.36
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	219,879,080.11	235,172,940.61
Бэлэн бүтээгдэхүүн	00.00	9,121,975.00
<b>Хангамжийн материал</b>	219,344,580.11	226,050,965.61
Аж ахуйн материал	95,786,197.72	96,529,197.72
Түлш, шатах тослох материал	25,058,400.00	20,952,930.50
Барилгын засварын материал	970,000.00	970,000.00
Хүнсний материал	31,666,670.00	38,011,560.00
Бусад хангамжийн материал	59,729,912.39	69,587,277.39
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,917,472,017.16</u></b>	<b><u>2,804,020,623.93</u></b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,917,472,017.16	2,804,020,623.93
<b>Биет хөрөнгө</b>	2,786,902,067.40	2,673,722,423.93
Барилга, байгууламж, орон сууц	2,739,119,949.78	2,739,119,949.78
Хуримтлагдсан элэгдэл	-445,826,580.28	-516,026,346.04
Авто-тээврийн хэрэгсэл	36,700,310.00	36,700,310.00
Хуримтлагдсан элэгдэл	-36,700,310.00	-36,700,310.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	495,869,392.80	515,255,192.80
Хуримтлагдсан элэгдэл	-171,182,870.66	-264,593,629.61
Тавилга, аж ахуйн эд хогшил	237,558,949.09	282,238,949.09

Хуримтлагдсан элэгдэл	-118,740,683.09	-140,372,268.48
Бусад үндсэн хөрөнгө	1,500,000.00	10,480,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-500,000.04	-1,483,333.41
Ном	49,103,909.80	49,103,909.80
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>130,569,949.76</b>	<b>130,298,200.00</b>
Програм хангамж	1,087,000.00	1,087,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-815,250.24	-1,087,000.00
Бусад биет бус хөрөнгө	130,298,200.00	130,298,200.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,566,508,189.65</u></b>	<b><u>3,349,524,305.52</u></b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>88,757,121.96</u></b>	<b><u>68,829,650.00</u></b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	88,757,121.96	68,829,650.00
<b>Өглөг</b>	88,757,121.96	68,829,650.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	146,500.00
<b>Бусад өглөг</b>	86,562,200.00	68,683,150.00
Байгууллагад төлөх өглөг	86,562,200.00	68,683,150.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,477,751,067.69</u></b>	<b><u>3,280,694,655.52</u></b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,477,751,067.69	3,280,694,655.52
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	614,871,262.10	614,871,262.10
Өмч: - төрийн	614,871,262.10	614,871,262.10
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,352,027,268.85	2,154,970,856.68
Өмнөх үеийн үр дүн	2,352,027,268.85	2,352,027,268.85
Тайлант үеийн үр дүн	00.00	-197,056,412.17
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	510,852,536.74	510,852,536.74
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,566,508,189.65</u></b>	<b><u>3,349,524,305.52</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,455,899,604.26</b>	<b>2,647,387,524.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>108,249,804.26</b>	<b>60,266,224.00</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	108,249,804.26	60,266,224.00

Төсөв байгууллагын өөрийн орлого	108,249,804.26	175,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,186,250.00	175,000.00
Бусад орлого	00.00	364,259.00
Борлуулалтын өртөг /ТӨҮГ/		
Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,347,649,800.00</b>	<b>2,587,121,300.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,203,649,800.00</b>	<b>2,450,276,800.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,203,649,800.00	2,450,276,800.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>144,000,000.00</b>	<b>136,844,500.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	144,000,000.00	136,844,500.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,399,051,815.62</b>	<b>2,844,443,936.17</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,399,051,815.62</b>	<b>2,844,443,936.17</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,298,473,144.16</b>	<b>2,766,222,749.61</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,601,694,884.43</b>	<b>1,967,924,108.64</b>
Үндсэн цалин	1,049,634,615.78	1,206,439,689.09
Нэмэгдэл	448,938,418.65	602,274,385.55
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	67,793,714.00
Урамшуулал	103,121,850.00	91,416,320.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>199,577,004.34</b>	<b>246,007,905.96</b>
Тэтгэврийн даатгал	137,550,847.04	165,946,897.40
Тэтгэмжийн даатгал	15,958,135.92	19,750,932.45
ҮОМШӨ-ний даатгал	8,342,781.91	10,884,060.64
Ажилгүйдлийн даатгал	7,431,153.38	9,227,377.78
Эрүүл мэндийн даатгал	30,294,086.09	40,198,637.69
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>149,112,645.04</b>	<b>117,913,197.94</b>
Гэрэл, цахилгаан	12,239,643.54	13,328,768.64
Түлш, халаалт	133,582,001.50	104,584,429.30
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>00.00</b>	<b>37,186,260.00</b>
Бичиг хэрэг	00.00	23,542,600.00
Тээвэр, шатахуун	00.00	13,643,660.00

<b>Нормативт зардал</b>	93,386,205.00	147,668,370.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	2,858,700.00
Хоол, хүнс	93,386,205.00	144,809,670.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,564,250.00	17,545,350.00
Урсгал засвар	23,564,250.00	17,545,350.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,290,000.00	20,692,963.84
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,959,500.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,290,000.00	17,733,463.84
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	228,848,155.35	211,284,593.23
Бараа үйлчилгээний бусад зардал	46,845,748.65	24,787,400.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	179,642,306.70	186,497,193.23
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	100,578,671.46	78,221,186.56
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	60,045,365.00	77,774,625.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,045,365.00	77,774,625.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	40,533,306.46	446,561.56
Төвлөрүүлэх шилжүүлэг	40,533,306.46	446,561.56
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>56,847,788.65</u></b>	<b><u>-197,056,412.17</u></b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>56,847,788.65</u></b>	<b><u>-197,056,412.17</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

#### Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	614,871,262.10	510,852,536.74	2,015,736,934.30	3,141,460,733.14
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	214,590,928.16	214,590,928.16
<b>2024 оны 12-р сарын</b>	<b>614,871,262.10</b>	<b>510,852,536.74</b>	<b>2,352,027,268.85</b>	<b>3,477,751,067.69</b>

<b>31-нээрх үлдэгдэл</b>				
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-197,056,412.17	-197,056,412.17
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>614,871,262.10</b>	<b>510,852,536.74</b>	<b>2,154,970,856.68</b>	<b>3,280,694,655.52</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

##### Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,357,684,450.00</u></b>	<b><u>2,590,580,459.00</u></b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,034,650.00</b>	<b>3,459,159.00</b>
Нийтлэг татварын бус орлого	10,034,650.00	3,459,159.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	10,034,650.00	3,094,900.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,848,400.00	2,919,900.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,186,250.00	175,000.00
Бусад орлого	00.00	364,259.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,347,649,800.00</b>	<b>2,587,121,300.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,203,649,800.00</b>	<b>2,450,276,800.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,203,649,800.00	2,450,276,800.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>144,000,000.00</b>	<b>136,844,500.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	144,000,000.00	136,844,500.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,166,492,431.60</u></b>	<b><u>2,673,601,180.07</u></b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,166,492,431.60</b>	<b>2,673,601,180.07</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,067,903,375.14</b>	<b>2,585,055,368.51</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,634,265,322.03</b>	<b>1,955,999,263.15</b>
Үндсэн цалин	1,041,718,883.85	1,186,678,912.32

Нэмэгдэл	451,804,120.63	610,275,394.95
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	65,461,329.00
Урамшуулал	140,742,317.55	93,583,626.88
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	194,126,144.52	243,040,943.08
Тэтгэврийн даатгал	133,236,232.23	166,548,775.39
Тэтгэмжийн даатгал	15,423,963.94	19,339,314.32
ҮОМШӨ-ний даатгал	8,003,807.67	9,891,833.69
Ажилгүйдлийн даатгал	7,375,685.33	9,452,123.91
Эрүүл мэндийн даатгал	30,086,455.35	37,808,895.77
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	95,654,443.54	118,788,888.44
Гэрэл, цахилгаан	12,239,643.54	17,999,768.64
Түлш, халаалт	79,722,000.00	95,807,959.80
Цэвэр, бохир ус	3,692,800.00	4,981,160.00
<b>Нормативт зардал</b>	74,851,170.00	149,951,910.00
Хоол, хүнс	74,851,170.00	149,951,910.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,812,250.00	17,609,050.00
Урсгал засвар	7,812,250.00	17,609,050.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,231,023.60	27,472,963.84
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,959,500.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,231,023.60	24,513,463.84
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	53,963,021.45	72,192,350.00
Бараа үйлчилгээний бусад зардал	42,252,321.45	63,290,250.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,710,700.00	8,902,100.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>98,589,056.46</b>	<b>88,545,811.56</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	58,055,750.00	88,099,250.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,055,750.00	88,099,250.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	40,533,306.46	446,561.56
Төвлөрүүлэх шилжүүлэг	40,533,306.46	446,561.56

<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>191,192,018.40</u></b>	<b><u>-83,020,721.07</u></b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>85,190,600.00</b>	<b>15,799,000.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>85,190,600.00</b>	<b>15,799,000.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	85,190,600.00	15,799,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,190,600.00	15,799,000.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-85,190,600.00</u></b>	<b><u>-15,799,000.00</u></b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	106,001,418.40	-98,819,721.07
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	296,673,229.45	402,674,647.85
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	402,674,647.85	303,854,926.78

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b><u>Татаас, санхүүжилтийн орлого</u></b>	<b>2,965,065,600.00</b>	<b>2,590,580,459.00</b>	<b>374,485,141.00</b>	
Улсын төсвөөс	2,473,622,200.00	2,450,276,800.00	23,345,400.00	97.40%
Орон нутгийн төсвөөс	136,844,500.00	136,844,500.00	0.00	99.00%
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	6,039,800.00	2,919,900.00	3,119,900.00	
Туслах үйл ажиллагааны орлого	644,600.00	539,259.00	105,341.00	
Урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх	347,914,500.00	-		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,965,065,600.00</b>	<b>2,640,301,030.07</b>	<b>324,764,569.93</b>	<b>96.40%</b>
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>2,965,065,600.00</b>	<b>2,689,370,180.07</b>	<b>275,695,419.93</b>	<b>90.70</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>2,411,602,300.00</b>	<b>2,199,040,206.23</b>	<b>212,562,093.77</b>	<b>88.80%</b>

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,139,211,600.00	1,955,999,263.15	183,212,336.85	96.90%
Цалин	1,342,883,100.00	1,186,678,912.32	156,204,187.68	93.10%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	796,328,500.00	769,320,350.83	27,008,149.17	96.70%
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>272,390,700.00</b>	<b>243,040,943.08</b>	<b>29,349,756.92</b>	95.20%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	228,808,200.00	205,232,047.31	23,576,152.69	96.10%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	43,582,500.00	37,808,895.77	5,773,604.23	96.00%
<b>Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал</b>	<b>118,844,500.00</b>	<b>118,788,888.44</b>	<b>55,611.56</b>	100.00%
Гэрэл цахилгааны зардал	18,000,000.00	17,999,768.64	231.36	100.00%
Түлш, халаалтын зардал	95,844,500.00	95,807,959.80	36,540.20	100.00%
Цэвэр, бохир усны зардал	5,000,000.00	4,981,160.00	18,840.00	100.00%
<b>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</b>	<b>480,223,800.00</b>	<b>282,995,273.84</b>	<b>197,228,526.16</b>	82.30%
Хоол	193,052,500.00	149,951,910.00	43,100,590.00	100.00%
Урсгал засварын зардал	18,000,000.00	17,609,050.00	390,950.00	84%
Бусад бараа үйлчилгээний зардал	186,309,400.00	63,290,250.00	123,019,150.00	97%
Мэдээллийн технологийн зардал	30,703,000.00	28,013,463.84	2,689,536.16	94.50%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	9,376,300.00	8,902,100.00	474,200.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,782,600.00	15,228,500.00	27,554,100.00	100.00%
<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>88,980,600.00</b>	<b>88,545,811.56</b>	<b>434,788.44</b>	
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	88,816,600.00	88,099,250.00	717,350.00	94.20%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	164,000.00	0	164,000.00	100.00%

Төвлөрүүлэх шилжүүлэг		446,561.56	-446,561.56	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		402,674,647.85	-402,674,647.85	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		303,854,926.78	-303,854,926.78	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 140,968.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 140,968.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийн үлдэгдлийг 3,257.5 мянган төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 60,266.2 мянган төгрөгөөр, гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, дотуур байрны хоолны зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг 53,563.0 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг 714.3 мянган төгрөгөөр, дотуур байрны хоолны зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг 23,885.9 мянган төгрөгөөр тус тус алдаатай тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д ерөнхий нягтлан бодогч .холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана” гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 1,816,853.3 мянган мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,526.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,814,326.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ..

#### 3.1 Төлбөрийн акт

1. Сургуулийн захирал, нярав нарт 673.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр олгосон, захиралд 853.6 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой, давхардуулан олгосон байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэж заасныг тус тус зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
2. Тайлант онд нярав нь 999.1 мянган төгрөгийн бараа материал дутагдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ”, гэж заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

### 3.2 Хариуцлага тооцох албан шаардлага

Нягтлан бодогч, нярав нар нь 2025 оны Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой

##### 1.Илрүүлэлт:

Эд хариуцагч нь тайлант оны үдийн хоолны хүнсний материалын зардлаас 13,300.4 мянган төгрөгийг дотуур байрны хоолны зардал руу гүйлгэн тайлагнасан, нягтлан бодогч нь эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж тооцоо бодоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.2-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байна" гэж заасныг зөрчсөн, "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Эд хариуцагчид бараа материалын тайланг тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд үнэн зөв гаргах, нягтлан бодогчид эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж, тооцоо бодсон баримт үйлдэж хэвших үүргүүдийг хүргүүлэн биелэлтийг тооцох;

##### 2.Илрүүлэлт:

Тооллогын комисс нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс тус бүрийн үлдэгдлийг баталгаажуулсан тооллогын дүгнэлт үйлдээгүй, 328,133.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн тооллогын бүртгэлийг ирүүлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.2-д "Тооллогын комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх үүрэгтэй"; гэснийг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Тооллогын комисс нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх, удирдлагаас тооллогын комиссын дүгнэлтэд хяналт тавьж хэвших

#### Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

##### 3.Илрүүлэлт:

Дотоод хяналтын нэгж нь тайлант онд 5 чиглэлийн 5 арга хэмжээнд хяналт хэрэгжүүлсэн гэсэн мэдээлэл ирүүлсэн боловч илэрсэн алдаа зөрчлийг нэгтгэж дүгнээгүй, зөвлөмж хүргүүлж, биелэлтийг тооцоогүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.7.3, 3.7.8 зэрэг заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын нэгжид төлөвлөсөн хяналт шалгалтыг бүрэн хийх, хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх үүргүүдийг өгч биелэлтийг тооцох;

**Нийцлийн аудиттай холбоотой асуудал**

4.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 501,589.7 мянган төгрөгөөр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 896,944.8 мянган төгрөгөөр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 74,358.8 мянган төгрөгөөр тус тус дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,1, 6.4.5-д заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй .

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Хүснэгт 6. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан алдаатай илнрхийлсэн	1	140,968.6			1	140,968.6	1	140,968.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>140,968.6</b>			<b>1</b>	<b>140,968.6</b>	<b>1</b>	<b>140,968.6</b>				

**Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Сургуулийн дотоод хяналтын нэгж хангалтгүй ажилласан	1	0.0						1	0.0
Эд хариуцагч нь 2025 оны хүнсний бараа материалын тайланг алдаатай гаргасан	1	13,300.4						1	13,300.4

Тооллогын комисс хангалтгүй ажилласан	1	328,133.0					1	328,133.0
Эд хариуцагч нь хүнсний материалын үлдэгдлийг дутагдуулсан	1	999.1	1	999.1				
Нэр бүхий ажилтнуудад тушаал шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл, ээлжийн амралтын олговор илүү тооцож олгосон	1	1,527.5	1	1,527.5				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>343,960.</b>	<b>2</b>	<b>2,526.6</b>			<b>3</b>	<b>341,433.4</b>

**Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансанд мэдээллийн мөнгөн дүнг үнэн зөв байршуулаагүй	1	1,472,893.3					1	1,472,893.3
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд аудитад ирүүлээгүй	1	0			1	0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,472,893.3</b>			<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>1,472,893.3</b>